

Германы Бундестагийн
тогтоолын үндсэн дээр
хөхиүлэн дэмжсэн:



Холбооны
Хүнс,
хөдөө аж ахуйн яам



ГЕРМАН-МОНГОЛЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ "ТОГТВОРТОЙ
ХӨДӨӨ АЖ АХУЙ" ТӨСӨЛ

GFA
CONSULTING GROUP
Generalbeauftragter BMEL
Büro Berlin

Нэвтрүүлэх үйлчилгээний ажлын төлөвлөлт

Б.Эрдэнэболор, PhD

Кэвин Галлагер, PhD

Хэрэгжүүлэгч байгууллагууд




Түши байгууллага



ГАРЧИГ

1. Төлөвлөлтийн ерөнхий загвар
2. Бэрхшээлийн тухай ойлголт, бэрхшээл шийдвэрлэх үе шатууд
3. Оролцооны аргаар нөхцөл байдлын шинжилгээ гүйцэтгэх зарим аргууд
4. Нэвтрүүлэх үйлчилгээний зорилго, зорилт тодорхойлох
5. Ажлын төлөвлөгөөний жишээ: “Ногоон алт” төслийн IV үе шатны Нэвтрүүлэх үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө


1. Төлөвлөлтийн ерөнхий загвар



Зургийн эх сурвалж: Hoffmann et al., 2007

Төлөвлөгөөний бүрдэл хэсгүүд


- Нэвтрүүлэх үйлчилгээний ажлын төлөвлөлтийг тодорхой зорилтот бүлэгт, тэдэнд тулгарсан **тодорхой бэрхшээлийг шийдвэрлэх**эд чиглүүлнэ.
- Төлөвлөгөөнд ямар ажил гүйцэтгэх, үүнд хэн хэрхэн оролцох, ямар багаж тоног төхөөрөмж, бусад хэрэгсэл шаардагдах, уг ажил үйлчилгээгээр дамжуулж ямар шийдлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ямар агуулгаар сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгөх зэрэг асуудлуудыг тусгана.
- Ажлын гүйцэтгэлийг дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлно.



Зургийн эх сурвалж: Зохиогч

Менежментийн тойрог

- Аливаа ажлыг хэрэгжүүлэх явцад залруулж, сайжруулах, шинээр эхлүүлэх шаардлага гардаг учраас ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт-үнэлгээг шугаман биш, харин тойрог хэлбэрээр дүрсэлдэг. Үүнийг “менежментийн тойрог” гэж нэрлэдэг.
- Нэвтрүүлэх үйлчилгээний ажлын төлөвлөлт нь нөхцөл байдлын шинжилгээнд (НБШ) үндэслэнэ. НБШ-гээр зорилтот бүлэг, тэдгээрт тулгарсан бэрхшээлүүд болон уг бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд шаардагдах тусламж, үйлчилгээг тодорхойлно.



Зургийн эх сурвалж: Зохиогч


2. Бэрхшээлийн тухай ойлголт, бэрхшээл шийдвэрлэх үе шатууд

Тодорхойлолт

Бэрхшээл гэж одоогийн ба зорьсон төлөв байдлын хоорондох ялгаврыг хэлнэ.

Бэрхшээл шийдвэрлэх гэж одоогийн төлөв байдлаас зорьсон төлөв байдалд хүрэх ухамсарт үйл явцыг хэлнэ.

Бэрхшээл шийдвэрлэх бүдүүвч



Бэрхшээл харьцангуй!

Аливаа асуудлыг хүн бүр өөрийнхөө өнцгөөр тусгаж авдаг учраас нэг хүний бэрхшээл гэж харж буй зүйл өөр хүний хувьд бэрхшээл биш байж болно. Иймд нэвтрүүлэх үйлчилгээний хувьд зорилтот бүлэгтээ тулгарсан бэрхшээлийг тэдний нүдээр харж байж л бүрэн таньж чадна.

Бэрхшээл шийдвэрлэх үе шатууд



Зургийн эх сурвалж: Зохиогч

3. Оролцооны аргаар нөхцөл байдлын шинжилгээ гүйцэтгэх зарим аргууд

1. Бэрхшээл тодорхойлох

- Асуулга
- Бүлгийн хэлэлцүүлэг
- Зорьсон төлөв байдлын зураглал
- Давуу, сул талууд, боломж, эрсдэлийн (SWOT) шинжилгээ

2. Бэрхшээл шийдвэрлэх хувилбаруудыг тодорхойлох

- Санал цуглуулах

3. Бэрхшээл шийдвэрлэх хувилбаруудаас сонголт хийж, үйл ажиллагааны зөвлөмж боловсруулах

- Оноогоор харьцуулах
- Санал хураах

Бэрхшээл тодорхойлох

Тодорхойлох дэс дараалал:

- Одоо би ямар нөхцөл байдалд байна вэ?
- Надад ямар өөрчлөлтүүд хэрэгтэй вэ?
- Уг өөрчлөлтүүдийг бий болгоход юу саад болж байна вэ?

Бэрхшээл тодорхойлох 6 асуулт:

- **Ямар** бэрхшээл үүссэн бэ?
- Бэрхшээл **хаана** байна вэ?
- **Яагаад** бэрхшээл үүссэн бэ?
- **Яаж** уг бэрхшээлийг шийдвэрлэх вэ?
- **Хэн** үүнд оролцох вэ?
- **Хэзээ** үүнийг шийдвэрлэх вэ?

Асуулга

- Хэрэв асуулгыг асуулга өгч буй хүмүүс өөрсдөө бөглөх бол асуулгын хуудас 1-2 нүүр, нийт асуулт 10-аас ихгүй байна.
- Хэрэв асуулгыг ярилцлага хэлбэрээр авч, хуудсыг бэлтгэгдсэн хүн бөглөх бол асуулгын хуудас 5-6 нүүр, 30 хүртэл асуулттай байж болно.
- Асуудлуудыг эрэмбэлэхэд, эсвэл тодорхой асуудлуудыг ойлгож, хүлээн зөвшөөрч буй эсэхийг шалгахад онооны шкал хэрэглэнэ. 1-5 оноотой шкал ашиглахад ихэнх хүмүүс асуултаа сайн уншилгүйгээр шууд “алтан дундаж” болох 3-ыг сонгодог тул 4 онооны шкал илүү тохиромжтой. Энэ тохиолдолд 1- маш чухал, 2- чухал, 3- үнэлэхэд хэцүү, 4- ач холбогдол багатай г.м. эрэмбэлнэ. Үүн дээр нэмж 1 буюу 5-д “мэдэхгүй” гэсэн хариулт оноож болно.
- **“Төлбөр төлөх боломж”** асуулт нь заавал төлбөр авах шууд утгаар биш, харин асуулга өгч буй тухайн асуудалд хүн хэр зэрэг ач холбогдол өгч буйг шууд бусаар тандахад нэмэртэй байдаг.

Асуулга

Санал авах хуудас (4 онооны шкал, 1-мэдэхгүй)

5. Бэлчээр ашиглалтын талаарх саналын хуудас

Дараахь өгүүлбэр тус бүрийг зөвшөөрч буй эсэхээ 1-5 хүртэл оноогоор илэрхийлнэ үү. Оноо өгөх дараалал:

5 = бүрэн зөвшөөрнө 4 = тодорхой хэмжээнд зөвшөөрнө 3 = зөвшөөрөхөд хэцүү
2 = зөвшөөрөхгүй 1 = мэдэхгүй

- 1 Манай суманд малын тоо толгой бэлчээрийн даацаас хэтэрсэн
- 2 Манай сумын бэлчээрийн ургамлын гарц жил ирэх тусам багасч байна
- 3 Бэлчээрийн ургамлын идэнги, шим тэжээл муудаж байна
- 4 Хавар ногоо цухуйх хугацаа хойшилсон
- 5 Малын өвөлжих тарга тэвээр муудаж байна
- 6 Цасны бүрхүүл зузаарч, өвөл мал бэлчээхэд хэцүү болж байна

Асуулга

“Төлбөр төлөх боломж” асуулт

Мал тэжээх, бордох талаар мэдээлэл, сургалт, мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлэхэд та хэдий хэмжээний төлбөр төлөх боломжтой вэ?

Шаардлагатай бол жилд 240 мянган төгрөгөөс илүүг төлөх боломжтой

Жилд 240 мянган төгрөг буюу сард 20 мянган төгрөг төлөх боломжтой

Жилд 120 мянган төгрөг буюу сард 10 мянган төгрөг төлөх боломжтой

Жилд 120 мянган төгрөг төлөх боломжгүй


Зургийн эх сурвалж: Erdenebolor & van den Fliert (2014)



Бүлгийн хэлэлцүүлэг

- Бүлгийн уулзалт зохион байгуулна.
- Оролцогч бүр тухайн бэрхшээлийг нэг буюу цөөн өгүүлбэрээр тодорхойлно.
- Тодорхойлолтуудыг хооронд нь харьцуулж, шүүн хэлэлцсэний эцэст тухайн шийдвэрлэх бэрхшээлийн талаар бүлгийн гишүүдийн олонхийн саналд нийцсэн нэгдсэн тодорхойлолтыг бичиж томъёолно.


Зорьсон төлөв байдлын зураглал



Увс аймгийн Зүүнговь сумын бэлчээрийн зорьсон төлөв байдлын зураглал

Зургийн эх сурвалж: Erdenebolor & van den Fliert (2014)

Зорьсон төлөв байдлын зураглал



Үр тарианы аж ахуйн зорьсон төлөв байдлын зураглал

Зургийн эх сурвалж: Зохиогч

Давуу, сул талууд, боломж, эрсдэлийн (SWOT) шинжилгээ

- SWOT шинжилгээг тодорхой байгууллага, ААН, эсвэл сум, баг, хоршоо, нөхөрлөл, бүлэг зэрэг нэгжийн төвшинд гүйцэтгэдэг.
- SWOT шинжилгээг гүйцэтгэхэд тухайн байгууллага, нэгжид тулгарсан асуудлуудыг төрөл бүрийн өнцгөөс харж, шинжлэх шаардлагатай.
- **Давуу тал:** Зорилгод хүрэхэд нэмэртэй дотоод хүчин зүйл буюу үзүүлэлт
- **Сул тал:** Зорилгод хүрэхэд саад болох дотоод хүчин зүйл
- **Боломж:** Зорилгод хүрэхэд эерэгээр нөлөөлөх гадаад хүчин зүйл
- **Эрсдэл:** Зорилгод хүрэхэд саад учруулж болзошгүй гадаад хүчин зүйл

Давуу, сул талууд, боломж, эрсдэлийн (SWOT) ШИНЖИЛГЭЭ

	Эерэг	Сөрөг
Дотоод хүчин зүйлс	Давуу талууд	Сул талууд
Гадаад хүчин зүйлс	Боломжууд	Эрсдэлүүд

Давуу, сул талууд, боломж, эрсдэлийн (SWOT) шинжилгээ

- SWOT шинжилгээ субъектив шинж чанартай (хүн бүр өөрийнхөөрөө хийдэг) учраас зайлшгүй багаараа хийх шаардлагатай
- Эцсийн дүгнэлт биш, ажилд тустай зөвлөмж гэж ойлговол зохино
- Төлөвлөлтийг хялбарчлах гэж SWOT хийснээ мартаж болохгүй
- Хүчин зүйлсээ маш тодорхой нэрлэх, ойлгомж муутай ерөнхий нэр томъёоноос татгалзах нь зөв
- Харьцангуй: жишээ авч болохоор ижил төстэй байгууллага, ААН, аймаг, сумтай харьцуулсан байдлаар эерэг, сөрөг, давуу, сул зэрэг үзүүлэлтийг тогтооно
- Үзүүлэлт тус бүрд оноо өгөх аргыг хэрэглэж болно
- Маш товч хэлбэрээр хийнэ. Нарийвчилсан шинжилгээ хийх шаардлагагүй.
- Харин шаардлагатай гэж үзвэл SWOT дээр тулгуурлан нарийвчилсан шинжилгээнүүдийг тусад нь хийж болно.

Бэрхшээл шийдвэрлэх хувилбаруудыг тодорхойлох

Санал цуглуулах арга (Brainstorming)

- Тухайн бэрхшээлийг шийдвэрлэх сонирхолтой хүмүүсийг цуглуулж уулзалт зохион байгуулна. Мэргэжлийн, мэргэжлийн бус, малчин, менежер, захирал, туслах ажилчин холилдсон “холимог бүлэг” бүрдүүлнэ.
- 30-60 минут орчим үргэлжилнэ



Зургийн эх сурвалж: medium.com

Санал цуглуулах арга (Brainstorming)

1. Оролцогчдод өгөх материал
2. Оролцогчид
3. Уулзалтын орчин
4. Уулзалтын явц



Зургийн эх сурвалж: medium.com

Санал цуглуулах арга (Brainstorming)

1. Оролцогчдод өгөх материал

- Уулзалтын хөтөлбөр
- Хэлэлцэх асуудлын талаарх баримт мэдээлэл
- Хэлэлцүүлгийн асуултууд


Санал цуглуулах арга (Brainstorming)

2. Оролцогчид

- Зөвхөн тухайн мэргэжлийн биш, өөр мэргэжлийн хүмүүс, малчид зэрэг төрөл бүрийн мэдлэг, мэргэжилтэй хүмүүсийг оролцуулах замаар төрөл бүрийн шинэлэг санаануудыг олж авах боломжтой.
- Хэлэлцүүлэг эхлэхээс өмнө оролцогчдод хэлэлцэх асуудал ба холбогдох мэдээллийг танилцуулна.

Санал цуглуулах арга (Brainstorming)

3. Уулзалтын орчин



Санал цуглуулах арга (Brainstorming)

4. Уулзалтын явц

- Хэлэлцүүлгийн эхэнд “бие халаалт” хийнэ. Жишээ нь төсөл, хөтөлбөрийн танилцуулга, оролцогчдын танилцуулга г.м.
- Эцсийн шийдвэр гаргахад биш, аль болох олон хувилбаруудыг тодорхойлоход зорино
- Санал цуглуулах явцад ямар ч шүүмж байж болохгүй
- Асуудалд хамааралгүй санал байсан ч авна
- Оролцсон хүн бүрээс саналуудыг нь авсны дараа ангилж, бүлэглэнэ.
- Урьдчилан тогтоосон шалгуурын дагуу саналуудыг эрэмбэлнэ. Үүнийг хэлэлцүүлгээс тусад нь хийж болно.

Бэрхшээл шийдвэрлэх хувилбаруудаас сонголт хийх

- Хувилбар бүр ямар давуу талтай вэ?
- Хувилбар бүр ямар сул талуудтай вэ?
- Хувилбаруудыг хооронд нь хэрхэн харьцуулах вэ?




Зургийн эх сурвалж: [translatemedia.com](https://www.translatemedia.com)

Сонголт хийх / Шийдвэр гаргах

Алхам	Анхаарах зүйлс
1. Бүх хувилбаруудаа томъёолж бэлтгэх.	<input type="checkbox"/> Өгөгдсөн нөхцөл байдалд хэрэгжих боломжтой бүх хувилбаруудыг тодорхойлно. <input type="checkbox"/> Нийт хувилбаруудаас урьдчилсан байдлаар цөөн хувилбаруудыг шалгаруулж, тоог нь цөөлж болно .
3. Холбогдох мэдээллийг цуглуулж, хувилбар бүрийн давуу ба сул талуудыг харьцуулах.	<input type="checkbox"/> Хангалттай бодит мэдээлэлд тулгуурлаж гаргасан шийдвэр зөв байх магадлалтай. <input type="checkbox"/> Хувилбар бүрийг хооронд нь харьцуулна.
4. Хамгийн зохистой хувилбарыг сонгох.	<input type="checkbox"/> Өмнөх үе шатуудын явц, үр дүнд тулгуурлан хамгийн зохистой хувилбарыг сонгоно.
5. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж эхлэх, хэрэгжилтийн явцад үнэлгээ хийж, зохих өөрчлөлтүүд оруулах.	<input type="checkbox"/> Гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэхэд зориулан хийгдэх ажил, хариуцах эзэн нь тодорхой үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулна. <input type="checkbox"/> Төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага зайлшгүй гардаг.

Хувилбаруудыг оноогоор харьцуулах



Хос хосоор нь харьцуулах,

Жигнэж харьцуулах,

Шугаман программчлал,

Санал хураах гэх мэт аргуудыг хэрэглэнэ.

Санал хураах



4. Нэвтрүүлэх үйлчилгээний зорилго, зорилт тодорхойлох

Хаана хүрэхээ мэдэхгүй бол хаашаа ч явж чадахгүй!

- **Зорилго (Goal):** хүрэхийг хүссэн ерөнхий үр дүн бөгөөд харьцангуй өргөн цар хүрээтэй, урт хугацаатайгаар тодорхойлдог.
- **Зорилт (Objective):** нь зорилгыг биелүүлэхэд шаардагдах үйл ажиллагаануудын хэмжиж болохуйц үр дүн.



Нэвтрүүлэх үйлчилгээний зорилго, зорилт тодорхойлох

- Нэвтрүүлэх ажлын зорилго, зорилтууд ХХААХҮ-ийн салбар дахь төрийн бодлогын дараахь чиглэлүүдэд уялдаж болно:
 - Хүний нөөц
 - Дэд бүтэц
 - Технологи
 - Санхүү
 - Бодлого
- Талуудын оролцоог хангаж ажиллах шаардлагатай.

Зорилт тодорхойлоход ашиглах SMART шалгуур үзүүлэлтүүд

- **Specific** (Тодорхой) – Ямар үр дүн хүсэн хүлээж байна вэ? Хэний оролцоо шаардлагатай вэ? Хэзээ, ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ? Яагаад энэ зорилтыг дэвшүүлсэн бэ?
- **Measurable** (Хэмжигдэхүйц) – Зорилго биелсэн эсэх, явцын дунд хүрсэн төвшинг хэрхэн хэмжих вэ?
- **Achievable** (Хүрэх боломжтой) –Энэ зорилтыг биелүүлэх бодит чадвар бий юу? Байхгүй бол бий болгож болох уу?
- **Relevant** (Хэрэгцээтэй) - Яагаад яг одоо энэ зорилтыг дэвшүүлэх болов? Ерөнхий том зорилгод уялдаж чадаж байна уу?
- **Time-Bound** (Хугацаатай) – Ямар хугацаанд энэ зорилт биелэгдэх ёстой вэ? Энэ хугацаа бодитой юу?

SMART шалгуурт нийцсэн ба нийцээгүй зорилт


- **SMART бус зорилт:** Бэлчээрийн менежментийг сайжруулах замаар талхагдлыг бууруулах
- **SMART зорилт:** Сумын ЗДТГ, малчдын оролцоотойгоор доройтсон бэлчээр нөхөн сэргээх, сүргийн менежментийг сайжруулах сургалт явуулж, мал, махны борлуулалтыг нэмэгдүүлэх замаар 2025 онд малын тоог хх толгойд хүргэж бууруулна (бэлчээрийн даацад нийцүүлэх).

5. Ажлын төлөвлөгөөний жишээ: Ногоон алт төслийн IV үе шатны Нэвтрүүлэх үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийн 2015 оны ажлын төлөвлөгөө

Зорилго: Малчдын хэрэгцээнд нийцсэн нэвтрүүлэх үйлчилгээний тогтолцоо бий болно.

Зорилтууд:

1. Нэвтрүүлэх үйлчилгээний бүтэц, чадавхийг бэхжүүлэх
2. МАА тогтвортой эрхлэх арга барилуудыг нэвтрүүлэх
3. Малчдын бизнесийн ур чадвар, бизнес эрхлэлтийг нэмэгдүүлэх.



Зургийн эх сурвалж: Эрдэнэболор, 2015

Зорилт 1: Нэвтрүүлэх үйлчилгээний бүтэц, чадавхийг бэхжүүлэх

Нэвтрүүлэх үйлчилгээний агуулга, арга зүйн чадавхи бий болгох чиглэлээр

- ҮХААГ, АБАХ-уудад мастер сургагч бэлтгэх сургалт
- МЭҮТ, СБАХ-уудад идэвхижүүлэгч бэлтгэх сургалт
- Оролцооны аргаар дүрс бичлэг бэлтгэх сургалт
- БАХ-ын төвшинд малчин зөвлөх бэлтгэх сургалт

Нэвтрүүлэх үйлчилгээний материаллаг баазыг сайжруулах чиглэлээр

- Сумд дахь малчдын сургалт мэдээллийн төвүүдийг тохижуулна.
- Сургалт-үйлдвэрлэлийн төслүүдийн хүрээнд үзүүлэх сургалтын объектууд бий болгоно.

Нэвтрүүлэх үйлчилгээний ур чадвар бүхий ХАА-н мэргэжилтэн бэлтгэх чадавхийг бэхжүүлэх чиглэлээр

- ХААИС-ийн Экстейншиний сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчилж, бүрэлдэхүүн сургуулийн багш нарыг нэвтрүүлэх үйлчилгээний арга зүйн сургалтад хамруулна.

Нэвтрүүлэх үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр

- ХААИС, ХААҮШУОНТ-ийн хамтын ажиллагааны санамж бичгийг шинэчилж, хамтын ажиллагааг идэвхижүүлнэ.
- ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх бодлогын зөвлөмж боловсруулна.

Зорилт 1: Нэвтрүүлэх үйлчилгээний бүтэц, чадавхийг бэхжүүлэх

Үр дүн	Шалгуур үзүүлэлт
1. Нэвтрүүлэх үйлчилгээний тогтолцооны чадавхийг сайжруулна.	50-иас цөөнгүй суманд малчдын сургалт, мэдээллийн төвийн үйл ажиллагааг идэвхижүүлнэ.
	Малчдын мэдээлэл, туршлага солилцоонд дүрс бичлэг ашиглах чадвар 5 суманд бий болно.
	600-аас цөөнгүй БАХ-д малчин зөвлөх бэлтгэгдэнэ.
	Нэвтрүүлэх үйлчилгээний зохицуулалт, хэрэгжүүлэлтийн чадавхи 76 суманд бий болно.
	Нэвтрүүлэх үйлчилгээг удирдах зохион байгуулах чадавхи 7 аймагт бий болно.
	ХААИС-ийн экстейншиний сургалтыг шинэчилж, сонгон суралцах оюутны тоог 150-д хүргэнэ.
	ХААҮШУОНТ, ХААИС-ийн үр дүнтэй хамтран ажиллагааг идэвхижүүлнэ.
	ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх бодлогын зөвлөмж боловсруулна.

Зорилт 2: Мал аж ахуй эрхлэх тогтвортой арга барилууд нэвтрүүлэх

Сургалт, нэвтрүүлэлтийн үндсэн агуулга

Бэлчээрийн хяналт, хамгаалал, зохистой ашиглалт	Малын ашиг шим, сүргийн менежмент	Тэжээлийн хангамж, тэжээллэг
<ul style="list-style-type: none"> • Бэлчээр өнжөөх, амраах, сэлгээх • Бэлчээр сайжруулах • Нөөц бэлчээрийн ашиглалт • Бэлчээрийн ургамал хамгаалал • Бэлчээрийн фото мониторинг • Бэлчээрийн зураглал 	<ul style="list-style-type: none"> • Шилмэл үүлдэр, омгийн хээлтүүлэгчээр нутгийн малыг сайжруулах • Бог малын хээлтүүлэгчийн сүрэг бүрдүүлэх • Үржлийн малаар сүрэг сэлбэх • Сүрэг доторх малыг ангилан ялгаж, ашиг муутай малыг заазлах • Мал сүргийг эрүүлжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Гар тэжээл, өвсөн дарш бэлтгэх • Ногоон тэжээл тариалж бэлтгэх • Хадлангийн талбай хашиж хамгаалах, сайжруулах • Өвөл, хаварт малыг зохистой жор, нормоор тэжээх

Сургалт, нэвтрүүлэлтийн аргууд

- Сургалт-үйлдвэрлэлийн төсөл, Үзүүлэх сургалт
- Малчнаас малчинд чиглэсэн мэдээлэл, туршлага солилцоо (БАХ, хот айлын төвшинд)
- Сонин хэвлэл, телевиз радиогоор явагдах мэдээлэл, сурталчилгаа (зайны сургалт)
- Малчдыг мэргэжлийн үйлчилгээнд холбох (мал эмнэлэг, үржлийн үйлчилгээ)

Зорилт 2: Мал аж ахуй эрхлэх тогтвортой арга барилууд нэвтрүүлэх

Үр дүн	Шалгуур үзүүлэлт
<p>2. Мал аж ахуй тогтвортой эрхлэх арга барилуудыг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.</p>	Бэлчээрийн хяналт, хамгаалалт, даац хэтрэлтийг бууруулах арга барилуудыг 10-аас цөөнгүй суманд нэвтрүүлнэ.
	Малын үүлдэр угсааг сайжруулах арга барилуудыг 40-өөс цөөнгүй БАХ-д нэвтрүүлнэ.
	Малын өвлийн нэмэгдэл тэжээлийг 40-өөс цөөнгүй БАХ-д нэмэгдүүлнэ.
	Ашиг муутай малын эргэлтийг түргэсгэх арга барилуудыг 6-аас цөөнгүй суманд нэвтрүүлнэ.
	Орон нутгийн мал эмнэлгүүдтэй 80-аас цөөнгүй БАХ мал эмнэлгийн үйлчилгээний гэрээ байгуулна.
<p>3. Мал аж ахуй тогтвортой эрхлэх арга барилуудыг БАХ-ын тогтолцоогоор дамжуулан малчдад сурталчилна.</p>	Үзүүлэх сургалт ба туршлага солилцох арга хэмжээнүүдэд 10 мянгаас цөөнгүй малчин хамруулна.
	Хэвлэмэл материал, дүрс бичлэг, телевиз, радиогоор 20 мянгаас цөөнгүй малчдад сурталчилна.
	Үйлдвэрлэлд амжилттай нэвтэрсэн бэлчээрийн тогтвортой менежментийн арга барилууд ба малчдын оролцоонд суурилсан нэвтрүүлэх үйлчилгээг бүсийн төвшинд сурталчилна.

Зорилт 3: Малчдын бизнесийн ур чадвар, бизнес эрхлэлтийг нэмэгдүүлэх

Сургалт, нэвтрүүлэлтийн агуулга, арга зүй

Сургалт-үйлдвэрлэлийн төсөл	Үзүүлэх сургалт, Мэдээлэл туршлага солилцоо, Зайны сургалт	Малчин өрхийг чадавхижуулах
<ul style="list-style-type: none">Хурга, төлөг, бяруу бордохСүү, мах, ноос, арьс шир боловсруулахТэжээл үйлдвэрлэлХагас эрчимжсэн мал аж ахуй эрхлэх		<ul style="list-style-type: none">Сүргийн эргэлт, орлого, зарлагын бүртгэлийн дэвтэр хөтлөхӨрхийг бүртгэлээ ашиглан сүргийн бүтцийг жил, улирлаар төлөвлөх

Сургалт-үйлдвэрлэлийн төслүүдэд баримтлах ерөнхий зарчмууд

- Төсөл бүрт техник, эдийн засгийн үндэслэл бүхий бизнес төлөвлөгөө боловсруулна.
- Төр, хувийн хэвшил, малчдын хамтын ажиллагааг идэвхижүүлнэ.
- Төслүүдийг бүсчилсэн байдлаар, харилцан уялдаатай хэлбэрээр хэрэгжүүлнэ.

Зорилт 3: Малчдын бизнесийн ур чадвар, бизнес эрхлэлтийг нэмэгдүүлэх

Үр дүн	Шалгуур үзүүлэлт
4. Малчдын бизнесийн чадавхи, бизнес эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	СБАХ-ыг түшиглэн байгуулагдсан 6-аас цөөнгүй малчдын хоршоодод бизнесийн төслүүд хэрэгжүүлэх замаар малчдад нэмэлт орлого бий болгоно.
	Сүргийн эргэлт, өрхийн орлого, зарлагын бүртгэлийг БАХ-ын гишүүн нийт малчин өрхийн 10-аас доошгүй хувьд нэвтрүүлнэ.

Жендерийн төлөвлөгөө

Зорилт	Шалгуур үзүүлэлт
<p>Мастер сургагч, Идэвхижүүлэгч, Малчин зөвлөхүүдийг хүйсийн зохистой харьцаагаар бэлтгэх</p>	<p>Мастер сургагчид: эмэгтэй/эрэгтэй=5/10, Идэвхижүүлэгчид: эмэгтэй/эрэгтэй=46/106, Малчин зөвлөхүүд: эмэгтэй/эрэгтэй=342/798</p>
<p>Үр шим хүртэгчдийн хүйсийн зохистой харьцааг хангах</p>	<p>Ерөнхий: Эмэгтэйчүүдийн оролцоо 30 хувиас багагүй байна. Үзүүлэх сургалтуудад оролцогчид: эмэгтэй/эрэгтэй=450/1050, Сургалт, мэдээллийн арга хэмжээнүүд: эм/эр=9000/21000 Гарын авлага, материал хүлээн авагчид: эм/эр=22500/72500 Хоршоодыг чадавхижуулах арга хэмжээнүүд: эм/эр=15/35 Хоршоодод суурилсан нэвтрүүлэх үйлчилгээ: эм/эр=60/140</p>
<p>Малчин эмэгтэйчүүдийн мэдээлэл, туршлага солилцоог хангах</p>	<p>76 сум бүрт малчин эмэгтэйчүүдийн зөвлөгөөн зохион байгуулж, 1140 малчин эмэгтэйг хамруулна.</p>
<p>Малчин эмэгтэйчүүдэд чиглэсэн</p>	<p>Төсвийн 15-аас доошгүй хувийг малчин эмэгтэйчүүдэд зориулагдсан сургалт, сурталчилгааны материалд зарцуулна.</p>
<p>Малчин эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлэх</p>	<p>МАА-н бүтээгдэхүүн боловсруулах сургалт-үйлдвэрлэлийн төслүүдэд 100-аас цөөнгүй эмэгтэйчүүд хамрагдана.</p>

Ашигласан эх сурвалж

Erdenebolor B., Baigal, L. (2012). Mining & Communities: Social impacts and stakeholders interactions in mining areas of Mongolia. Хэвлэгдээгүй.

Erdenebolor, B., van de Fliert, E. (2014). Making Extension Work For Herders. A participatory assessment of needs and opportunities for the Green Gold – Agricultural Extension Component (2013-2016). Хэвлэгдээгүй.

Hoffmann, V. etc. (2007). Rural Communication and Extension. Хичээлийн слайдууд. Штуттгарт: Хоэнхаймын их сургууль.

Эрдэнэболор, Б. (2008). Экстейншиний үйлчилгээ. Хичээлийн слайдууд. Улаанбаатар: Хөдөө аж ахуйн их сургууль.

Эрдэнэболор, Б. (2015). Ногоон алт төслийн Нэвтрүүлэх үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө. Мастер сургагч бэлтгэх сургалтад тавьсан илтгэл. Улаанбаатар, 2015.03.16.